НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2024/21/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2024 он | Эн Ай Ти Эс баланс АудитХХК-ийн захирал: Ш.Ичинхорлоо<br>Утас: 99102291 Цахим хаяг:ichinkhorloo2023@gmai.com<br>Аудитын менежер: И.Туяа<br>Утас: 99298711 Цахим хаяг: tuyaishjamts@gmai.com<br>Ахлах аудитор: С.Алтанхундага<br>Утас:99457188. Цахим хаяг: altankhundagas@gmai.com<br>Аудитор: С.Удвал.<br>Утас: 99085158 Цахим хаяг: udval1979@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.02.23 № 418

танай ______________-ны №______________-т

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА,
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
Д.ШИНЭБАЯР ТАНАА

# АУДИТЫН ДҮГНЭЛТ

## Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1, 6 дугаар зүйлийн 6.4.8, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, ХХОАТ-ын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

Тайлант онд ЭМДС-ийн санхүүжилтийн орлогын нэхэмжилсэн дүнгээс нийт 949.9 сая төгрөгийн хасалт хийгдсэн нь төлөвлөсөн орлогын төлөвлөгөөний биелэлтэд нөлөөлсөн;

Ажиллагсдаас суутган тооцсон НДШ-ийн 547.6 сая, ХХОАТ-ын 312.8 сая төгрөгийг өглөгийг тухай бүр барагдуулаагүйгээс тайлант хугацаанд 860.4 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй.

## Асуудлыг онцолсон хэсэг

Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны орлогын нийт дүн өмнөх оноос 1,246.5 сая төгрөг буюу 9.5 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь ЭМЯ-аас

тус төвд 1,580.0 сая төгрөгийг тайлант онд нэмж хуваарилсан, үндсэн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 2.9 дахин өссөн нь голлон нөлөөлжээ. Харин ЭМДС-ийн санхүүжилтийн орлого өмнөх оноос 19.7 хувиар буурсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв нь тайлант онд 1 хөтөлбөр, 3 зорилт, 94 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилт 85.3 хувийн биелэлттэй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 2,233,743,245.30 | 2,155,351,743.50 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 444,334,225.82 | 419,742,598.68 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 444,334,225.82 | 419,742,598.68 |
| 3121 | Төгрөг | 444,334,225.82 | 419,742,598.68 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 444,334,225.82 | 419,742,598.68 |
| 33 | АВЛАГА | 231,401,625.00 | 580,986,653.00 |
| 332 | Төлбөртэй үйлчилгээний авлага | | 579,483,023.00 |
| 335 | Бусад авлага | 231,401,625.00 | 1,503,630.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 231,401,625.00 | 1,503,630.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 1,558,007,394.48 | 1,154,622,491.82 |
| 351 | Түүхий эд материал | 727,934,841.95 | 383,486,536.80 |
| 3513 | Эм боох материал | 727,934,841.95 | 383,486,536.80 |
| 353 | Бэлэн бүтээгдэхүүн | 113,119,398.75 | 89,127,879.00 |
| 354 | Хангамжийн материал | 716,953,153.78 | 682,008,076.02 |
| 3541 | Бичиг хэргийн материал | | 2,063,750.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 71,623,289.00 | 56,274,025.00 |
| 3544 | Түлш, шатах тослох материал | 12,060,000.00 | 1,810,000.00 |
| 3547 | Бусад хангамжийн материал | 633,269,864.78 | 621,860,301.02 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 20,276,595,652.21 | 21,275,743,309.81 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 20,276,595,652.21 | 21,275,743,309.81 |
| 392 | Биет хөрөнгө | 19,371,271,402.21 | 20,370,483,309.81 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 15,880,997,181.36 | 18,277,047,049.36 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -2,375,514,363.20 | -2,966,335,426.80 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 631,598,524.20 | 601,862,090.20 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -368,078,349.22 | -432,921,916.27 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 835,698,422.50 | 882,182,145.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -562,271,380.82 | -651,008,089.74 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 520,390,782.51 | 531,067,282.51 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -145,628,158.57 | -205,145,455.37 |
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 9,052,708,524.08 | 9,766,109,392.04 |
| 39212 | Хуримтлагдсан элэгдэл | -4,099,581,833.48 | -5,433,325,813.97 |
| 39217 | Ном | 952,052.85 | 952,052.85 |
| 393 | Биет бус хөрөнгө | 905,324,250.00 | 905,260,000.00 |
| 39301 | Програм хангамж | 5,285,000.00 | 5,285,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -5,220,750.00 | -5,285,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 905,260,000.00 | 905,260,000.00 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 22,510,338,897.51 | 23,431,095,053.31 |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 2,404,324,231.49 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 2,404,324,231.49 |
| 413 | Өглөг | | 2,404,324,231.49 |
| 4131 | Ажилчидтай холбогдсон өглөг | | 860,482,602.64 |
| 4132 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | 1,521,943,378.85 |
| 4136 | Бусад өглөг | | 21,898,250.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | 21,898,250.00 |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 22,510,338,897.51 | 21,026,770,821.82 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 22,510,338,897.51 | 21,026,770,821.82 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 4,788,841,055.75 | 4,788,841,055.75 |
| 51101 | Өмч: - төрийн | 4,788,841,055.75 | 4,788,841,055.75 |

| | | | |
|---|---|---|---|
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 2,499,482,995.05 | 1,015,914,919.36 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 2,499,482,995.05 | 2,499,482,995.05 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | -1,483,568,075.69 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 15,222,014,846.71 | 15,222,014,846.71 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 22,510,338,897.51 | 23,431,095,053.31 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 13,102,943,732.27 | 14,349,416,100.34 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 2,690,859,789.78 | 5,407,439,713.34 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 2,690,859,789.78 | 5,407,439,713.34 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 317,494,791.00 | 1,960,367,007.50 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 724,642,007.50 |
| 120009 | Туслах үйл ажиллагааны орлого | | 1,235,725,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 1,665,749,428.77 | 3,121,538,058.46 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 707,615,570.01 | 325,534,647.38 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 10,412,083,942.49 | 8,941,976,387.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 10,346,948,867.50 | 8,941,976,387.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 10,346,948,867.50 | 8,941,976,387.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 16,369,801,572.33 | 15,830,919,146.04 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 16,369,801,572.33 | 15,830,919,146.04 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 16,191,949,660.31 | 15,811,987,146.04 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 7,105,958,031.88 | 7,601,381,246.37 |
| 210101 | Үндсэн цалин | 3,160,195,532.41 | 4,332,567,337.07 |
| 210102 | Нэмэгдэл | 3,170,716,746.84 | 2,749,551,704.42 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 278,961,772.45 | 268,867,155.90 |
| 210104 | Урамшуулал | 496,083,980.18 | 250,395,048.98 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 919,728,544.21 | 1,023,856,055.60 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 625,535,704.36 | 618,399,911.32 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 73,560,700.00 | 137,775,320.90 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 58,848,600.00 | 135,732,064.45 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 14,662,139.85 | 11,795,313.97 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 147,121,400.00 | 120,153,444.96 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 728,049,920.52 | 1,076,675,330.15 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 86,558,734.60 | 194,585,930.05 |
| 210302 | Түлш, халаалт | 437,982,469.52 | 684,481,420.29 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 203,508,716.40 | 197,607,979.81 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 397,522,044.49 | 576,428,691.32 |
| 210401 | Бичиг хэрэг | 24,309,605.00 | 10,902,820.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 105,154,430.00 | 98,466,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 16,667,559.08 | 19,917,587.21 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 215,358,646.67 | 315,629,031.16 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 36,031,803.74 | 131,513,525.98 |
| 2105 | Нормативт зардал | 3,655,803,645.32 | 2,685,979,025.98 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,282,254,345.32 | 2,685,979,025.98 |
| 210502 | Хоол, хүнс | 373,549,300.00 | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 849,315,666.00 | 105,203,989.75 |
| 210604 | Урсгал засвар | 849,315,666.00 | 105,203,989.75 |

| | | | |
|---|---|---|---|
| 2107 | Томилолт, зочны зардал | 10,919,000.00 | 5,982,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,919,000.00 | 5,982,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 63,150,187.50 | 24,314,99600 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 38,554,439.00 | 2,188,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 7,000,000.00 | 7,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 900,000.00 | 871,830.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 792,000.00 | 522,857.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 155,000.00 | 198,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,713,409.00 | 2,713,409.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 112,500.00 | 86,350.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 12,922,839.50 | 10,733,310.87 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,461,502,620.39 | 2,712,165,310.87 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 482,910,078.22 | 540,677,490.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,676,500.00 | 6.089,550.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,975,916,042.17 | 2,165,398,270.87 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 177,851,912.02 | 18,932,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 176,030,000.02 | 18,932,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 160,000,000.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,030,000.02 | 18,932,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,821,912.00 | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,821,912.00 | |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | -3,266,857,840.06 | -1,481,503,045.70 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 346,598.71 | 2,065,029.99 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 346,598.71 | |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө | | 2,065,029.99 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН(4)=(145-225) | -346,598.71 | -2,065,029.99 |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | -3,267,204,438.77 | -1,483,568,075.69 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| | | | |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 16,012,254,928.39 | 10,324,860,371.50 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 328,131,391.90 | 1.962.367.007.50 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 328,131,391.90 | 1.962.367.007.50 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 328,131,391.90 | 1.962.367.007.50 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 328,131,391.90 | 726,642,007.50 |
| 120009 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 1,235,725,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 15,684,123,536.49 | 8,362,493,364.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 15,618,988,461.50 | 8,362,493,364.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 15,618,988,461.50 | 8,362,493,364.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 15,034,689,774.59 | 10,304,379,098.64 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 15,034,689,774.59 | 10,304,379,098.64 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 14,856,837,862.57 | 10,285,447,098.64 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 7,105,958,031.88 | 6,848,940,872.49 |
| 210101 | Үндсэн цалин | 3,129,382,383.44 | 3,716,715,597.05 |
| 210102 | Нэмэгдэл | 3,201,529,895.81 | 2,733,078,537.69 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 278,961,772.45 | 263,497,561.19 |
| 210104 | Урамшуулал | 496,083,980.18 | 135,649,176.56 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 919,458,939.85 | 915,813,826.84 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 625,266,100.00 | 803,136,706.67 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 73,560,700.00 | 31,315,261.34 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 58,848,600.00 | 24,421,782.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 14,662,139.85 | 5,149,200.04 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 147,121,400.00 | 51,790,876.79 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 728,049,920.52 | 753,985,073.40 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 86,558,734.60 | 189,460,930.05 |
| 210302 | Түлш, халаалт | 437,982,469.52 | 400,028,792.54 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 203,508,716.40 | 164,495,350.81 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 253,418,615.58 | 213,647,449.91 |
| 210401 | Бичиг хэрэг | 23,965,231.00 | 7,784,220.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 107,473,000.00 | 88,216,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 16,668,258.58 | 17,882,730.91 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 92,893,961.00 | 90,685,750.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,418,165.00 | 9,078,749.00 |
| 2105 | Нормативт зардал | 4,377,805,775.52 | 883,115,050.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,847,255,975.52 | 860,920,270.00 |
| 210502 | Хоол, хүнс | 515,611,200.00 | 517,981,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 14,938,600.00 | 22,194,780.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 873,083,923.00 | 96,826,590.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,935,000.00 | 16,826,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 871,148,923.00 | 80,000,190.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 10,919,000.00 | 5,982,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,919,000.00 | 5,982,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 73,785,748.00 | 20,965,746.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 38,554,439.00 | 2,188,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 7,000,000.00 | 7,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 900,000.00 | 871,830.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 792,000.00 | 522,857.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 155,000.00 | 198,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,713,409.00 | 2,713,409.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 112,500.00 | 86,350.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 23,558,400.00 | 7,384,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 514,357,908.22 | 546,170,490.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 511,681,408.22 | 25,209,990.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,676,500.00 | 2,979,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 177,851,912.02 | 18,932,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 176,030,000.02 | 18,932,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 160,000,000.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,030,000.02 | 18,932,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,821,912.00 | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,821,912.00 | |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 977,565,153.80 | 20,481,272.86 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 545,052,840.00 | 45,072,900.00 |
| 22 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авах | 545,052,840.00 | 45,072,900.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | 545,052,840.00 | 45,072,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 545,052,840.00 | 45,072,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -545,052,840.00 | -45,072,900.00 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 432,512,313.80 | -24,591,627.14 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 16,012,254,928.39 | 444,334,225.82 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 44,433,422,582.00 | 419,742,598.68 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|
| 202 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 4,788,841,055.75 | 15,222,139,457.80 | 5,766,562,822,73 | 25,777,543,336.28 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | -124,611.09 | 124,611.09 | 0.0 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,788,841,055.75 | 15,222,014,846.71 | 5,766,687,433,73 | 25,777,543,336.28 |
| Тайлант оны үр дүн | | | -3,267,204,438.77 | -3,267,329,049.86 |
| 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 4,788,841,055.75 | 15,222,014,846.71 | 2,499,482,995.05 | 22,510,338,897.51 |
| 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 4,788,841,055.75 | 15,222,014,846.71 | 2,499,482,995.05 | 22,510,338,897.51 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,788,841,055.75 | 15,222,014,846.71 | 2,499,482,995.05 | 22,510,338,897.51 |
| Тайлант үеийн үр дүн | | | -1,483,568,075.69 | -1,483,568,075.69 |
| 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 4,788,841,055.75 | 15,222,014,846.71 | 1,015,914,919.36 | 21,026,770,821.82 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 10,978,306,200.00 | 9,142,736,681.84 | 1,835,569,518.16 | 83.28 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 10,978,306,200.00 | 9,097,663,781.84 | 1,880,642,418.16 | 82.87 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 10,974,306,200.00 | 9,090,731,781.84 | 1,887,574,418.16 | 82.81 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 6,740,000,000.00 | 6,249,453,835.69 | 490,546,164.31 | 92.72 |
| 210101 | Үндсэн цалин | 3,650,000,000.00 | 3,363,631,666.85 | 247,428,133.15 | 93.15 |
| 210102 | Нэмэгдэл | 2,600,000,000.00 | 2,510,605,050.26 | 89,394,949.74 | 96.56 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 248,000,000.00 | 254,276,573.38 | -6,276,573.38 | 102.53 |
| 210104 | Урамшуулал | 242,000,000.00 | 120,940,545.20 | 121,059,454.8 | 49.98 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,185,203,700.00 | 565,813,826.84 | 619,389,873.16 | 47.74 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 955,799,100.00 | 453,136,706.67 | 502,662,393.33 | 47.41 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 72,447,000.00 | 31,315,261.34 | 41,131,738.66 | 43.23 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 57,957,600.00 | 24,421,782.00 | 33,535,818.00 | 42.14 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 9,000,000.00 | 5,149,200.04 | 3,850,799.96 | 57.21 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 90,000,000.00 | 51,790,876.79 | 38,209,123.21 | 57.55 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 970,200,000.00 | 743,985,073.40 | 226,214,926.60 | 76.68 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 190,000,000.00 | 179,460,930.05 | 10,539,069.95 | 94.45 |
| 210302 | Түлш, халаалт | 614,000,000.00 | 400,028,792.54 | 213,971,207.46 | 65.15 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 166,200,000.00 | 164,495,350.81 | 1,704,649.19 | 98.97 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 221,567,500.00 | 184,614,249.91 | 36,953,250.09 | 83.32 |
| 210401 | Бичиг хэрэг | 10,000,000.00 | 6,199,220.00 | 3,800,780.00 | 61.99 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 88,400,000.00 | 78,216,000.00 | 10,184,000.00 | 88.48 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 20,301,500.00 | 17,882,730.91 | 2,418,769.09 | 88.09 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 92,865,900.00 | 73,237,550.00 | 19,628,350.00 | 78.86 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,000,000.00 | 9,078,749.00 | 921,251.00 | 90.79 |
| 2105 | Нормативт зардал | 1,729,200,000.00 | 717,358,770.00 | 1,011,841,230.00 | 41.49 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,250,000,000.00 | 716,308,770.00 | 533,691,230.00 | 57.30 |
| 210502 | Хоол, хүнс | 470,000,000.00 | | 470,000,000.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 9,200,000.00 | 1,050,000.00 | 8,150,000.00 | 11.41 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 72,000,000.00 | 100,576,590.00 | -28,576,590.00 | 139.69 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 12,000,000.00 | 20,576,400.00 | -8,576,400.00 | 171.47 |
| 210604 | Урсгал засвар | 60,000,000.00 | 80,000,190.00 | -20,000,190.00 | 133.33 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 7,000,000.00 | 3,982,000.00 | 3,018,000.00 | 56.89 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,000,000.00 | 3,982,000.00 | 3,018,000.00 | 56.89 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 25,301,500.00 | 18,776,946.00 | 6,524,554.00 | 74.21 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,850,000.00 | 0.0 | 6,850,000.00 | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 7,000,000.00 | 7,000,000.00 | 0.0 | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 900,000.00 | 871,830.00 | 28,170.00 | 96.87 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 550,000.00 | 522,857.00 | 27,143.00 | 95.06 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 198,000.00 | 198,000.00 | 0.0 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 2,713,500.00 | 2,713,409.00 | 91.00 | 100.0 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 0.00 | 86,350.00 | -86,350.00 | - |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 7,000,000.00 | 7,384,500.00 | 384,500.00 | 105.49 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,833,500.00 | 506,170,490.00 | -482,336,990.00 | 920.3 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,833,500.00 | 503,191,490.00 | -482,357,990.00 | 1006.4 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,000,000.00 | 2,979,000.00 | 21,000.00 | 99.30 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,000,000.00 | 6,932,000.00 | 2,932,000.00 | 173.30 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 4,000,000.00 | 6,932,000.00 | 2,932,000.00 | 173.30 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,000,000.00 | 6,932,000.00 | 2,932,000.00 | 173.30 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 45,072,900.00 | -45,072,900.00 | |
| | Дотоод эх үүсвэрээр | | 45,072,900.00 | -45,072,900.00 | |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 10,978,306,200.00 | 9,944.860,371,50 | 1,033,445,828.5 | 90.6 |
| 134 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 8,904,122,000.00 | 8,362,493,364.00 | 541,628,636.00 | 93.9 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 8,904,122,000.00 | 8,362,493,364.00 | 541,628,636.00 | 93.9 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 2,074,184,200.00 | 1,582,367,007.50 | 491,817,192.50 | 76.2 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 423,000,000.00 | 375,517,007.50 | 47.482.992.5 | 88.8 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос | 1,206,850,000.00 | 1,206,850,000.00 | 0.0 | 100.0 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 444,334,200.00 | | 0.00 | 100.00 |
| | | | 444,334,200.00 | -444,334,200.00 | |
| | | | 419,742,598.68 | -419,742,598.68 | |

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 2,809,249.6 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрсэнээс аудитын явцад 127,295.4 мянган төгрөгийн 1 алдааг залруулсан, 2,258,831.2 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлсэн, 423,123.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бараа материалыг буруу ангилж бүртгэсэн | 1 | 127,295.4 | | | 1 | 127,295.4 | 1 | 127,295.4 | | | | |
| Дүн | 1 | 127,295.4 | | | 1 | 127,295.4 | 1 | 127,295.4 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| | Нийт зөрчил | Үүнээс |
|---|---|---|

| Зөрчлийн товч утга | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | То о | Дүн | Тоо | Дүн | То о | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| ЭМДС-ийн нэхэмжлэл-ээс хасалт хийгдсэн | 1 | 949,940.1 | | | 1 | 949,940.1 | | | | | | |
| НДШ, ХХОАТ-ын өглөг үүсгэсэн | 1 | 860,404.4 | | | 1 | 860,404.4 | | | | | | |
| Тайлант оны зарим худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуу лаагүй | 1 | 423,123.0 | | | | | 1 | 423,123.0 | | | | |
| Дүн | 3 | 2,233,467.5 | | | 2 | 1,810,344.5 | 1 | 423,123.0 | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Худалдан авах ажиллагааны 2 гэрээг хугацаа хоцроож, 5 гэрээ болон хандив авсан хөрөнгийн мэдээллийг байршуулаагүй | 1 | 448,486.7 | | | 1 | 448,486.7 | | |
| Дүн | 1 | 448,486.7 | | | 1 | 448,486.7 | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | - | - | - | - | - | - | | |
| Нийт дүн | 1 | 448,486.7 | | | 1 | 448,486.7 | | |

**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 100/2172 5351 Улаанбаатар хот

НТАГ-2024/21/НА-СТА-ТШЗ

## Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хандив тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлбар 325,534,647 төгрөг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай хийсэн 122,925,130.00 төгрөгийн 2 гэрээ, нийт 448,459,777.00 (дөрвөн зуун дөчин найман сая, дөрвөн зуун тавин есөн мянга долоон зуун далан долоо) төгрөгийн 3 мэдээллийг ил тод байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3.*"Тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх*", 6 дугаар зүйлийн 6.1."энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох*" журмын 4.2.1.11-д *"хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Шилэн дансны цахим системд мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга Д.Шинэбаяр, ерөнхий нягтлан бодогч Ч.Отгонбаяр нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН[1]:**

ЭН АЙ ТИ ЭС БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Ш.ИЧИНХОРЛОО

АУДИТОР С.УДВАЛ

ХЯНАСАН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Х.ТҮВШИНБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР Я.АЛТАНЦЭЦЭГ

7145633
УХА0612 9077278

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

002042675

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 101/21725351 Улаанбаатар хот

НТАГ-2024/21/НА-СТА-ТШ

## Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн орлогын нэхэмжилсэн дүнгээс нийт 949,940,070.00 (есөн зуун дөчин есөн сая есөн зуун дөчин мянга дал) төгрөгийн хасалт хийгдсэн нь төлөвлөсөн орлогын төлөвлөгөөний биелэлтэд нөлөөлсөн байна. Энэ нь СТОУС 4.23 *"Аж ахуйг нэгжийн нөөцийг хянахын тулд тухайн нөөцөөс ирээдүйд олох эдийн засгийн үр өгөөж нь өөр нэг талд биш харин тухайн аж ахуйн нэгжид шууд эсвэл дам хэлбэрээр ордог байх ёстой"*, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 "*хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;*" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох*" журмын 4.2.1.11-д "*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн орлогоос хасалт хийгдсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга Д.Шинэбаяр, ерөнхий нягтлан бодогч Ч.Отгонбаяр нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН**[1]**:**

ЭН АЙ ТИ ЭС БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ — Ш.ИЧИНХОРЛОО

АУДИТОР — С.УДВАЛ

ХЯНАСАН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА — Х.ТҮВШИНБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР — Я.АЛТАНЦЭЦЭГ

1117145633
УХА0612 9077278

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

002042677

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 02/21725351 Улаанбаатар хот

НТАГ- 2024/21/ НА-СТА-ТИЕ5

## Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажиллагсдаас суутган тооцсон нийгмийн даатгалын шимтгэлийн 547,646,812.00 төгрөг, хувь хүний орлогын албан татварын 312,757,618.00 төгрөгийн өглөгийг тухай бүр барагдуулаагүйгээс тайлант хугацаанд 860,404,430.00 (найман зуун жаран сая дөрвөн зуун дөрвөн мянга дөрвөн зуун гуч) төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.*"төсвийг зохистой удирдаж, авлага, өр, төлбөр үүсгэхгүй байх"*, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.*"Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө"*, Хувь хүний орлогын татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6.*"Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 25.2-т зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ"* гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох*" журмын 4.2.1.11-д *"хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Тайлант хугацаанд өр төлбөр үүсгэсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга Д.Шинэбаяр, ерөнхий нягтлан бодогч Ч.Отгонбаяр нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН[1]:**

| | |
|---|---|
| ЭН АЙ ТИ ЭС БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ | Ш.ИЧИНХОРЛОО |
| АУДИТОР | С.УДВАЛ |
| ХЯНАСАН: | |
| САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА | Х.ТҮВШИНБАЯР |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Я.АЛТАНЦЭЦЭГ |

1117145633
УХА0612 9077278

1 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

002042679